



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Шинжилгээ авах баг томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, Монгол Улсын Шадар Сайдын 2020 оны “Стратеги, төлөвлөгөө батлах тухай” 26 дугаар тушаалын 3.9.4, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /ковид-19/-ын онцгой нөхцөл байдал үүссэн үед үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг шуурхай хангах зорилгоор шаардлагатай ажилтнуудаас шинжилгээ авах багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

| | |
|-----------------------|---|
| Багийн дарга: | Б.Алтантуяа (Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлага, дотоод хяналтын албаны аюулгүй ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн) |
| Нарийн бичгийн дарга: | Б.Өнөрбаяр (Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны чанар баталгаажуулалтын мэргэжилтэн) |
| Гишүүд: | Б.Батмагнай (Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны их эмч) Б.Дэлгэрмаа (Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны их эмч) Х.Эрдэнэ (Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны их эмч) Э.Очирбат (“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Зорчигч үйлчилгээний албаны эмнэлгийн хэсгийн их эмч) М.Ариунболд (“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Зорчигч үйлчилгээний албаны эмнэлгийн хэсгийн их эмч) Ю.Одгэрэл (“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Зорчигч үйлчилгээний албаны эмнэлгийн хэсгийн их эмч) Ё.Наран (“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Зорчигч үйлчилгээний албаны эмнэлгийн хэсгийн сувилагч) |

А.Эрдэнэзаяа ("Буянт-Ухаа" Олон улсын нисэх буудлын Зорчигч үйлчилгээний албаны эмнэлгийн хэсгийн сувилагч)

М.Мөнхтуяа ("Буянт-Ухаа" Олон улсын нисэх буудлын Зорчигч үйлчилгээний албаны эмнэлгийн хэсгийн сувилагч)

Н.Энхболд (Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны эмч)

О.Гантуул (Сэргээн засах амралтын сувилагч бариач)

Ж.Тулга (Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны Тээвэр, ашиглалтын хэлтсийн дарга)

Б.Өнөрбаяр (Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны чанар баталгаажуулалтын мэргэжилтэн)

С.Чинзориг (Аж ахуй, үйлчилгээний албаны ахлах мэргэжилтэн)

М.Дондовдорж (Аюулгүй байдал, хамгаалалтын албаны үзлэг шалгалт, хамгаалалтын хэсгийн хамгаалалтын ахлагч)

2. Коронавируст халдвар /ковид-19/ илрүүлэх PCR болон түргэвчилсэн шинжилгээ авах ажлыг зохион байгуулах, зохих бэлтгэлийг хангах, холбогдох түр заавар, төсөв, төлөвлөгөөг боловсруулж батлуулах, мэргэжлийн байгууллагаас сургалт, дадлага авах, онцгой нөхцөл байдал үүссэн үед ажилчдаас шинжилгээг шуурхай авах, шинжлүүлэх ажлыг зохион байгуулахыг багийн дарга /Б.Алтантуяа/-д даалгасугай.

3. Шинжилгээ авах багийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг төсөвлөн зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар /Б.Батхишиг/-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн Гамшгаас хамгаалах штаб /П.Гантөгс/-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ